



“ЗУЛ БУЯН УНДРАХ” ХХК-ИЙН ӨВӨРХАНГАЙ
АЙМГИЙН ТАРАГТ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ
MV-62000086 ТООТ ИХ БУЛАГ-1 БАРИЛГЫН
ЭЛС-ХАЙРГАНЫ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХӨТӨЛБӨР

Төсөл хэрэгжүүлэгчийн регистрийн дугаар: 3550583



ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн танилцуулга

Төслийн нэр

Их булаг-1 Барилгын элс-хайрганы орд төсөл

**Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн
нэгж байгууллага**

- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “ЗУЛ БУЯН УНДРАХ” ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 1011001100
- Регистрийн дугаар: 3550583
- Хаяг: Өвөрхангай, Арвайхээр, 13-р баг, Онги, мэргэд 3, 306, 31
- Утас: 99111937, 99111433


Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Монгол улсын засаг захиргааны нэгжийн хувьд Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутаг дэвсгэрт Их булаг нэртэй газарт орших Их булаг-1 элс-хайрганы уурхай нь Улаанбаатар хотоос баруун урагш 420 км, Арвайхээр хотоос зүүн хойш 7 км зайд Онгийн голын баруун дэнжийн хэсэгт байрлана. Аймгийн төвөөс Улаанбаатар хот хүртэл холбосон хатуу хучилттай замтай. Ордын төв цэгийн солбицол Уртраг 104°20'32.8" Өргөрөг 44°59'23.3" байршина.

Хүснэгт 1 Төслийн талбайн солбицол

ТЗ-ийн дугаар:	MV-62000086							
Ордын нэр:	Их булаг							
Талбайн нэр:	Их булаг							
Төрөл:	Ашиглалтын тусгай зөвшөөрөл							
Талбай /га/:	32.44							
Тусгай зөвшөөрлийн талбай								
№	X (UTM48N)	Y (UTM48E)	Өргөрөг (WGS-84)			Уртраг (WGS-84)		
			град	мин	сек	град	мин	сек
1	5131553.887	335613.814	46	19	3.43	102	51	53.14
2	5131166.831	334962.082	46	18	50.33	102	51	23.18
3	5130817.44	335215.081	46	18	39.24	102	51	35.44
4	5131225.83	335875.20	46	18	53.04	102	52	5.77


“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-6200086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 1 Төсөл хэрэгжих талбай зураг

Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь ямар нэг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газартай хиллэдэггүй болно.

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-6200086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 2 Талбайн одоогийн байдал

Хүснэгт 2 Ил уурхайн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо, хэмжээ
1	Элс-хайрганы геологийн нөөц	мян.м³	1786.5
	Үүнээс - (А) зэргээр	мян.м ³	220.9
	- (В) зэргээр	мян.м ³	892.0
	- (С) зэргээр	мян.м ³	673.5
2	Уурхайн хил хязгаар доторх геологийн нөөц	мян.м³	1096.0
	Үүнээс - (А) зэргээр	мян.м ³	215.7
	- (В) зэргээр	мян.м ³	880.3
3	Үйлдвэрлэлийн нөөц	мян.м³	1067.69
	Үүнээс - (А) зэргээр	мян.м ³	210.1

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


	- (B) зэргээр	мян.м ³	857.6
4	Уурхайн нийт хөрс хуулалт	мян.м ³	62.5
5	Хөрс хуулалтын дундаж коэффициент	м ³ /м ³	0.06
6	Уурхайн жилийн хүчин чадал	мян.м ³	20.00
7	Уул-тээврийн үндсэн тоног төхөөрөмж:		
	Экскаватор HYUNDAI HL480L	ш	1
	Автосамосвал HOWO sinotruck, 25тн,	ш	9
	Утгуурт ачигч, ZL-50	ш	1
	Бутлан ангилах үйлдвэр LIMING	ш	1
	Бетон зуурмагийн үйлдвэр HZS75	ш	1
	Бетон шахагч помп 38х-SR2	ш	1
	Миксер HOWO	ш	2
8	Хөрөнгө оруулалт	сая төг	1639.3
9	- Уурхайн үндсэн тоног төхөөрөмж	сая төг	160.0
	- Туслах тоног төхөөрөмж	сая төг	70.0
	- Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд	сая төг	523.0
	- Цахилгаан, ус хангамж	сая төг	19.1
	- Уурхай болон үйлдвэрийн барилга байгууламж	сая төг	151.4
	- Бусад хөрөнгө оруулалт	сая төг	46.2
	- Эргэлтийн хөрөнгө	сая төг	669.6
10	Ажиллах горим:		
	- Жилд ажиллах хоногийн тоо		180
	- Ээлжийн тоо		1
	- Ээлжийн үргэлжлэх хугацаа		10
11	Ашиглалтын систем	Авто тээвэртэй	
12	Ажиллагсдын тоо:	хүн	23
	- Ажиллагсдын дундаж цалин	мян. төг	1382.3
13	Уурхайн жилийн дундаж зардал	сая төг	1177



Зураг 3 Төслийн талбайн өнөөгийн харагдах байдал

Ил уурхайн эцсийн байдлын хил, хүрээ хязгаар

Уурхайн хил хязгаар доторх элс, хайрганы давхарга нь хэвтээ уналтай, ашигт давхаргын зузаан нь дунджаар 2.2-10 м, хучаас хөрсний зузаан дунджаар 0.3-0.4 м байна. Ордын геологийн нөөцийн блокууд нь хойд, зүүн, урд хэсгээрээ ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилээр хязгаарлагдаж байгаа тул ил уурхайн хажуугийн өнцгөөр үүсэх хаягдлыг 16.9 мян.м³ тооцон хасаж 1096.02 мян.м³ нөөцийг олборлох боломжтой байна.



Хүснэгт 3 Ил уурхайгаар олборлох боломжтой нөөцийн тооцоо

№	Нөөцийн зэрэглэл, блоккийн дугаар	Блоккийн талбай	Ашигт малтмалын дундаж зузаан	Ашигт малтмалын нөөц	Тусгай зөвшөөрлийн талбайн хилээр хасагдах нөөц	Уурхайн хүрээнд орох нөөц
		мян.м ²	м	мян.м ³	мян.м ³	мян.м ³
1	А-I	14.3	7.7	109.9	4.0	105.9
2	А-II	14.8	7.5	111.0	1.1	109.9
3	Нийт баттай (А) нөөц	29.1	7.6	220.9	5.1	215.7
4	В-I	32.9	7.7	253.0	2.8	250.2
5	В-II	43.3	7.8	337.7	2.8	334.8
6	В-III	38.6	7.8	301.4	6.1	295.2
7	Нийт бодитой (В) нөөц	114.8	7.8	892.0	11.8	880.3
8	Ордын А+В нийт нөөц	143.9	7.7	1112.92	16.90	1096.02

Ашиглалт явуулах ил уурхайн урт 419 м, өргөн 342 м бөгөөд уурхайн нийт талбайн хэмжээ 14.4 га болно.

Тайлбар: MV-62000086 тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий [Company]-ийн Ихбулаг ордод ЭБМЗ-өөр нийт элс-хайрганы ашигт давхаргын эзлэхүүн 1786.5 мян.м³, үүнээс хайрга 845.1 мян.м³, элс 941.34 мян.м³ бүртгэгдсэн байна. Ордын үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ны өдрийн 203 тоот тушаалыг үндэслэн тооцсон. Ашиглалтын үеийн хаягдлыг 2.59%, тооцоолон үйлдвэрлэлийн нөөцийг 1067.7 мян.м³ нөөц нь дээр үндэслэн Уул уурхайн зураг төслийн “Жеммери” ХХК нь энэхүү ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэсэн байна.

Ил уурхайн жилийн хүчин чадал

Зул буян ундрах ХХК-ийн баримталж байгаа бодлогын хүрээнд уул уурхайн зураг төсөл боловсруулах компанид өгсөн төслийн даалгаврыг үндэслэн ашиглалтын жил, хүчин чадал зэргийг сонгосон. Ил уурхайн техникийн хүчин чадал, хөрөнгө оруулалт, дотоодын зах зээл зэргийг үндэслэн төслийн хүчин чадлыг жилд 20.0 мян.м³ барилгын элс-хайрга олборлон, борлуулахаар төсөлд тусгаж байна.

Уурхай нь хоногт 10 цагийн үргэлжлэлтэй, 1 ээлжээр, 180 хоног ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь улирлын чанартай тул уурхайн техникийн операторууд, жолооч, туслах ажилчид болон ИТА нарыг улирлын чанартай ажиллахаар төсөлд тусгасан.

Хүснэгт 4 Уурхайн ажиллах горим

№	Уурхайн ажиллах горим	Нэгж	Утга
1	Жилд ажиллах календарь хоног	Хоног	180
2	Амралт, баяр ёслолын үеийн амралтын хоног	Хоног	7
3	Цаг агаарын хүндрэлийн сул зогсол	Хоног	8
4	Жилд ажиллах хоног	Хоног	165
5	Хоногийн ээлжийн тоо	-	1
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	10
7	Ээлжид цэвэр ажиллах цаг	Цаг	8

Ил уурхайн ашиглалтын систем

Орд нь харьцангуй тэгш гадаргуутай, хөрсний зузаан бага, ашигт давхарга нь дунджаар 5.6м, ерөнхийдөө тогтвортой зузаантай, хэвтээ уналтай.

“Ихбулаг” элс-хайрганы ордын гадаргуу нь харьцангуй тэгш (өндөржилтийн зөрүү 1744-1732м). Элс-хайрганы ашигт давхарга хэвтээ байрлалтай. Хөрсний чулуулаг нь элсэнцрээс тогтох бөгөөд 0.3-0.4 м, дунджаар 0.36м байна.

Хучаас болон ашигт давхарга нь литологийн хувьд сэвсгэр буюу маш сул барьцалдсан хэмхдэст хурдас тул хөрс хуулах болон ашигт давхаргыг олборлох үед өрөмдлөг тэсэлгээний ажил шаардагдахгүй, экскаватороор шууд ухаж ачих боломжтой.

Олборлолтын ажлыг ордын зүүн хойд хэсгээс эхлэн ашигт давхаргын ерөнхий суналд хөндлөн чиглэлд уурхайлах бөгөөд бага хэмжээний хучаас чулуулгийг ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Байгалийн болон уул техникийн хүндрэл харьцангуй бага газрын гадаргад ойр.

Дээрх уул техникийн нөхцөл, захиалагчийн өгсөн ажлын даалгаврыг үндэслэн ордыг ил уурхайн аргаар авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгалаа. Ордын тогтцоос хамааран хөрсийг гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн түр овоолго үүсгэнэ.

Хүснэгт 5 Ашиглалтын технологийн схем

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Авто тээвэртэй ашиглалтын систем	Хөрс хуулалт	Ухаж ачих
		Тээвэрлэх (Гадаад ба Дотоод овоолго)
	Элс-хайрга олборлолт	Ухаж ачих
		Тээвэрлэх (Үйлдвэрлэлийн талбай) Тээвэрлэх (Бетоны үйлдвэр)

Хүснэгт 6 Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих	Тоо хэмжээ
---	--------------------	--------	------------

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

		НЭГЖ	
1	Ил уурхайн гүн	м	8
2	Ил уурхайн хажуугийн өнцөг	град	65
3	Хөрсний доголын өндөр	м	0.4
4	Олборлолтын доголын өндөр	м	4
5	Авто замын өргөн	м	10
6	Авто замын налууугийн хэмжээ	‰	80
7	Ажлын талбайн өргөн	м	25


Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Уурхайн элс-хайрга олборлолтын ажлыг тасралтгүй гүйцэтгэх, хөрс хуулалтын коэффициентийг харьцангуй тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хийж гүйцэтгэв.

Хөрс хуулалтыг ордын тогтцоос хамааран гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн түр овоолго үүсгэнэ. Төсөл хэрэгжих 54 жилийн хугацаанд 62.5 мян.м³ хөрс хуулах, 1067.7 мян.м³ элс-хайрганы давхарга олборлоход хөрс хуулалтын дундаж коэффициент 0.06м³/м³ байхаар байна.

Хүснэгт 7 Календарчилсан төлөвлөгөө

№	Нөөцийн зэрэглэл, блоккийн дугаар	Үйлдвэрлэлийн нөөц, мян.м ³	Ашиглалтын жилүүд, мян.м ³											
			1	2	3	4	5	6-10	11-20	21-30	31-40	41-50	51-54	
1	А-I	103.1							93.0	10.1				
2	А-II	107.0	20	20	20	20	20.0	7.0						
3	Нийт багтай (А) нөөц	210.1	20.0	20.0	20.0	20.0	20.0	100.0	10.1					
4	В-I	243.7								189.9	53.8			
5	В-II	326.2									146.2	180.0		
6	В-III	287.7										20.0	200	67.7
7	Нийт бодитой (В) нөөц	857.6								189.9	200.0	200.0	200.0	67.7
8	Ордын А+В нийт нөөц	1067.7	20.0	20.0	20.0	20.0	20.0	100.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	67.7
9	Хуулах хөрс	62.5	1.7	0.50	1.65	0.90	0.00	5.44	13.07	12.90	12.69	9.75	3.96	



Зураг 4 Уурхайн календарчилсан төлөвлөгөө

Ил уурхайн технологи

Хөрс болон барилгын чулуу олборлолтын ажилд [Companу]-ийн өөрийн техник болох HYUNDAI HL480L маркийн 2.3 м³ утгуурын багтаамжтай 1 ш экскаватор, Nowo маркийн 25тн даацтай 9 ш түрээсийн автосамосвал уурхайн тээвэрт ашиглана. Хөрсний овоолго, бутлан ангилах хэсэгт болон туслах ажилд XCMG ZL-50 маркийн 1 ш утгуурт ажиллана.

Ухаж ачих, тээвэрлэх процесс

Ил уурхайн хөрс хуулалт болон элс-хайрганы олборлолтын ажилд 2.3 м³ шанаганы багтаамжтай HYUNDAI HL480L маркийн экскаватор ажиллана.

Ил уухайн тээвэр

Уурхайн хөрс болон элс-хайрга тээвэрлэлтийн механикжуулалтын ажлыг автосамосвалын тусламжтай гүйцэтгэнэ. Элс-хайргыг автосамосвалаар тээвэрлэн уурхайгаас баруун урагш 12.5км ийн зайд байрлах “Зул буян ундрах” ХХК-ийн бутлан ангилах болон бетон зуурмагийн үйлдвэрийн талбай руу тээвэрлэн овоолго үүсгэн агуулахад хураана. Элс-хайрга тээвэрлэх 12.5 км-ийн 4.5км нь ердийн шороон зам бөгөөд тухайн 4.5 км-ийн замыг хайрган хучилттай зам тавихаар төслийн хөрөнгө оруулалтад зардлыг тусгалаа. Замын маршрутыг зохих байгууллагаар батлуулах, уг замыг стандартад заасан шаардлагын дагуу байгуулах, арчлах зэрэг Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолыг ханган “Зул буян ундрах” ХХК үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.



Зураг 5 Уурхайгаас үйлдвэр хүртэлх элс хайрга тээвэрлэх замын маршрут.

Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолын 3-р бүлэгт тусгасан болно.

Овоолгын аж ахуй

Төслийн эхний жилд 0.3м-ийн зузаантай өнгөн хөрсийг ил уурхайн урд хэсэгт түр овоолго үүсгэнэ. Ил уурхайн өрнөлгүй болсон хэсэгт хөрсний түр овоолгыг эргүүлэн буулгах ба ашиглаж дууссаны дараа ашиглагдсан орон зайд түр дотоод овоолго үүсгэж давхар техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэнэ.

Ордын элс-хайрга агуулсан ашигт давхаргын хэвтээ тогтоц болон хучаас өнгөн хөрс 0.3-0.4м байгаа нь дотоод овоолго хийх уул-геологийн таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Тус ордод ашиглалтын эхнээс эхлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ. Ашиглагдсан ил орон зайг дүүргэх боломжгүй тул шимт болон өнгөн хөрсийг хуулан уулын ажлын өрнөлгүй болсон хэсэгт шимт хөрсөөр хучих ажлыг хийнэ.

Хучаас хөрсний зузааны өөрчлөлтөөс хамааруулан ажлын доголын өндрийг 0.3-0.4 метрээр тооцсон. Экскаватор нь ашиглалтын явцад хөрсийг ашиглагдсан орон зайд буулгаж, элс-хайрганы давхаргыг автосамосвалд ачиж тээвэрлэнэ.


Хүснэгт 8 Уурхайн ашиглалтын жилийн хөрс хуулалтын хэмжээ

№	Үзүүлэлт	Ашиглалтын жилүүд						
		1 дэх жил	2 дах жил	3 дах жил	4 дэх жил	5 дах жил	6-10 дах жил	11-54 дах жил
1	Хуулах хөрс, мян.м ³	1.70	0.50	1.65	0.90	0.00	5.36	52.37
2	Сийрэгжилтийн коэфф	1.2	1.2	1.2	1.2	1.2	1.2	1.2
3	Тээвэрлэх хөрсний хэмжээ, мян.м ³	2.04	0.60	1.98	1.08	0.00	6.43	62.85
4	Хөрсний овоолго өсөн нэмэгдэхээр, мян.м ³	2.04	2.64	4.63	5.71	5.71	12.13	74.98

Ил уурхайн 2026 оны олборлолт, геологийн нөөц

II.1. Ил уурхайн 2026 оны хил, хүрээ хязгаар

Уурхайн 2026 оны хүрээ хил хязгаар доторх элс, хайрганы давхарга нь хэвтээ уналтай, ашигт давхаргын зузаан нь дунджаар 2.2-10 м, хучаас хөрсний зузаан дунджаар 0.3-0.4 м байна. Ордын геологийн нөөцийн А-II гэсэн блокоос 20.0 мян.м³ элс-хайрга олборлож, 1.7 мян.м³ хөрс хуулж, 1.7 мян.м³ × 1.2 = 2.04 мян.м³ болж сийрэгжсэнээр хөрсний гадаад болон дотоод овоолгод хураана. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.09 м³/м³ байна. Уурхайн 2026 оны төлөвлөлтөөр уурхайн урт дунджаар 134м, өргөн 70 м, гүн 8.0 м ил уурхайгаар 0.57 га талбай өртөхөөр төлөвлөгдсөн байна.



Зураг 6 Ил уурхайн 2026 оны элс-хайрга олборлох төлөвлөлтийн байдал.

Ил уурхайн ашиглалтын систем

Орд нь харьцангуй тэгш гадаргуутай, хөрсний зузаан бага, ашигт давхарга нь дунджаар 5.6м, ерөнхийдөө тогтвортой зузаантай, хэвтээ уналтай.

“Ихбулаг” элс-хайрганы ордын гадаргуу нь харьцангуй тэгш (өндөржилтийн зөрүү 1744-1732м). Элс-хайрганы ашигт давхарга хэвтээ байрлалтай. Хөрсний чулуулаг нь элсэнцрээс тогтох бөгөөд 0.3-0.4 м, дунджаар 0.36м байна.

Хучаас болон ашигт давхарга нь литологийн хувьд сэвсгэр буюу маш сул барьцалдсан хэмхдэст хурдас тул хөрс хуулах болон ашигт давхаргыг олборлох үед өрөмдлөг тэсэлгээний ажил шаардагдахгүй, экскаватороор шууд ухаж ачих боломжтой.

Олборлолтын ажлыг ордын зүүн хойд хэсгээс эхлэн ашигт давхаргын ерөнхий суналд хөндлөн чиглэлд уурхайлах бөгөөд бага хэмжээний хучаас чулуулгийг ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Байгалийн болон уул техникийн хүндрэл харьцангуй бага газрын гадаргад ойр.

**“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот
Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Хүснэгт 9 2026 оны хөрс хуулалтын хэмжээ

№	Үзүүлэлт	2026 он
1	Хуулах хөрс, мян.м ³	1.70
2	Сийрэгжилтийн коэффициент	1.2
3	Тээвэрлэх хөрсний хэмжээ, мян.м ³	2.04
4	Хөрсний овоолго өсөн нэмэгдэхээр, мян.м ³	2.04

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Их булаг ордод 2026 онд 21.7 мян.м³ уулын ажил хийгдэх бөгөөд үүний улмаас уурхайн орчны экологид тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл бий болохоор байна. Ордыг ил уурхайгаар ашиглах нөхцөлд ил уурхай овоолго, барилга байгууламж, автомашины зам зэрэгт зориулсан тодорхой хэмжээний газар шаардлагатай болно. Ашиглалтын хугацаанд нийт 0.57 га, талбайн гадаргуу өртөгдөж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Уур амьсгал. Манай орны ихэнх нутгийн адил эх газрын уур амьсгалтай бөгөөд чийглэгдүү сэрүүвтэр зунтай, цас багатай, хахир өвөлтэй дэд мужид хамаарагддаг. Агаарын жилийн дундаж температур нь 2-6 хэм байх бөгөөд газрын гадаргууд ирэх нарны нийлбэр цацрагийн жилийн дундаж хэмжээ 1100-1200 квт-цаг\м² хүрнэ. Өвлийн их хүйтрэлт 1-р сард -33 хэм хүртэл хүйтрэх ба зун 6-р сард +32 хэм хүртэл дулаардаг. Жилд унах тунадасны хэмжээ 200-250 мм байх ба 8-р сард бороо их ордог бөгөөд өвөлдөө цас бага унадаг. Цасан бүрхэвчийн дундаж зузаан 10-13 см, салхины жилийн дундаж хурд нь баруун, баруун хойноос 8-10 м\сек. байх бөгөөд зонхилох чиглэл нь баруун хойноос чиглэлтэй.

Хөрс, ургамал. Хөрсний хувьд хангайн хөрсний их мужийн Хангайн дэд мужийн хээрийн хүрэн хөрсний бүсэд багтдаг. Хур тунадас нь голдуу зун, намрын сард унах ба түр зуурын хүчтэй бороо, мөндрийн үерийн усаар хөрс нэлээд эвдэрч, идэгдсэн байдаг. Судалгааны талбайд нунтаг карбонатлаг хүрэн, цайвар хүрэн хөрс зонхилох ба говьтой залгаа өмнөд хэсгээрээ хээрийн хөрс зонхилно. Уулс хоорондын хөндий хотгор ба жижиг сайр жалгуудад хар хүрэн, нам газрын бараан хөрс багагүй байх ба хужир, мараа, элс, намаг ч тохиолдоно.

Ургамлын хувьд Евро-Азийн хээрийн их мужийн дагуур Монголын дэд их мужийн Орхон Сэлэнгийн дэд мужид хамаарна. Дундаж өндөр ба нам уулсын хангайн өмнөд хэв шинжийн алаг өвс, бутлаг алаг өвст хээрийн ургамал зонхилох ба өвс ургамал сийрэг тачирдуу байдаг.

Ус зүй. Талбай нь Төв Азийн гадагш урсгалгүй усны ай савд багтдаг. Тус дүүрэгт хур тунадас дунд зэрэг унадаг. Ус цаг уурчдын судалгааны үр дүнгээс харахад жилд унах хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаар дулааны улиралд 200-250 мм, хүйтний улиралд 10-20мм-д хэлбэлзэнэ.

Томоохон гол нь Онгийн гол юм. Онгийн гол нь Хангайн нурууны баруун Өмнөт Онгон хайрхан уулын өвөр биеэс эх аван олон жижиг горхи, голуудтай нийлэн урссаар судалгааны талбайн дундуур Зүүн баян улаан, Арвайхээр сумдын нутгаар урсан өнгөрнө.

Онги голын өргөн дунджаар 20-30м, үертэй үедээ 40-50м хүртэл хэлбэлзэнэ. Дундаж гүн 5-10 сард 30дагуух зарим газарт намаг шавартай, булан -70см, гүн цүнхээлдээ 1м хүрнэ. Хур бороо ихтэй үертэй үед эргээ халин хавтгайран тэлж, гүн нь 1-1.5м хүрэх ба түүнээс ч ихсэх тохиолдол байдаг. Онги голын голдирлын дагуух зарим газарт намаг, шавартай булан тохой элбэг. Хуучин голдирлын ором, тохойрсон эрэг, гуу элбэгтэй. Эдгээр нь 200-300м өргөнтэй, зарим газраараа салаалж голдоо хуурай сайр бүхий жижиг арал үүсгэсэн байдаг. Зарим булаг, горхи нь зуны улиралд хур борооны усаар тэтгэгдэх үедээ түр зуурын урсгалтай болно. Уулын бэл, зарим жалгын адаг болон голын эрэг орчмын цөөн тооны булаг Онгийн голдоо урсан нийлдэг. Судалгааны талбай нь хуурай сайр, жалга элбэгтэй.

Хүн ам, эдийн засаг дэд бүтэц. Арвайхээр хот нь Улаанбаатар хотоос 420 км зайтай, баруун 5 аймаг дамжин өнгөрдөг хатуу хучилттай магистрал замаар холбогдсон, тээвэр холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн. Арвайхээр сум нь 2022 оны байдлаар 9400 өрх, 32347 хүн ам, 252.0 мянган толгой малтай, засаг захиргааны анхан шатны нэгж 13 багт хуваагдаж, хүн амын 90 хувь нь сумын төвд оршин сууж байна. Арвайхээр хот нь Засаг захиргааны анхан шатны нэгж 13 багтай. Иргэдийн ая тухтай амрах, чөлөөт цагаа идэвхтэй үр бүтээлтэй өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж ихээр нэмэгдэж, гэрэлт гудамж, спорт зал, кино театр, усан спортын цогцолбор баригдаж орон нутагтаа ая тухтай, сэтгэл ханамжтай ажиллаж амьдрах таатай орчин нөхцөл бүрдсэн.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчин: Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас 42 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 3 буюу 7.1% нь “бага”, 19 буюу 45.2% нь “дунд”, 18 буюу 42.8% нь “их”, 2 буюу 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Эндээс үзэхэд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ дундаас их хэмжээнд байхаар байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ агаарын чанарт 16%, газрын гадарга, хэвлийд 19%, хөрсөн бүрхэвчид 17%, газрын доорх усанд 14%, ургамлан нөмрөгт 17%, амьтны аймагт 17% гэсэн үзүүлэлт гарч байгаа ба газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл илүү байна.

Хүний эрүүл мэнд: Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

Нийгэм эдийн засаг: Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслөөс төсөл хэрэгжих Өвөрхангай аймгийн Тарагт сумын нийгэм эдийн засагт ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах зэргээр ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх нь боломжтой байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (цаашид БОМТ гэх) байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байхаар тус тус зохицуулсан билээ.

Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага мөн тавигдсан.

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

Байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 19,635,000 төгрөг төсөвлөв.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2026 оны нийт зардал /сая төгрөг/	
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,5
1.1		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,845
1.2		Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	6.0
1.3		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,2
		Удирдлага зохион байгуулалт	1,0
1.4		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,5
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	0.59
		Нийт зардал	19,635

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1	Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлөх	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	Уурхай орчимд	м/с	-	-	-	Салхины хүч ихээр нэмэгддэг үеүдэд	MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”
		Уурхайн тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	Уурхай орчим	Л	-	-	1,5	Хуурайшилттай үеүдэд 7 хоногт 1-2 удаа	
	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгартал болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Засварын газар	Ш	0.5	1	0.5	Үйл ажиллагааны туршид	MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”
	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн замд хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Уурхай орчимд	ш	0.25	2	0.5	Үйл ажиллагааны туршид	MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”
		Уурхайн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, сайжруулсан хайрган хучилттай болгох, цаашид арчилж тордох	Уурхай орчимд	км	-	-	0,5		
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
	Элс хайрга олборлолтын хэмжээ нэмэгдсэн үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн	Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу	Уурхай орчим	МЗ	-	-	Нөхөн сэргээлт	Үйл ажиллагааны туршид	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	
	талбайн хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	байршуулж, хэлбэржүүлж хамгаалах					төлөвлө өгүй		хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-2019 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS5850-2019 “Хөрсний чанар, Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”,
Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах		Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг зэрэг талбайг цементлэх, цаашид засч сайжруулж байх	Уурхай орчим	-	-	-	0,5	Үйл ажиллагааны туршид	
Усан орчин									
Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчин бохирдуулах		Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаргал болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Засварын цех	-	-	-	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	Үйл ажиллагааны туршид	MNS5914-2008 “Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт”, MNS5915-2008 “Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, буруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
	Уурхайн ухааш үүсэх, далан байгуулах, суваг шуудуу хатах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсцын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх	Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр, төрх байдлыг өөрчлөхгүй байх	Уурхайн бүсэд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал”,
Ургамлан нөмрөг									
	Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар тээвэрлэх ба хүнд даацын машин механикмын нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах, ургах чадвараа алдах	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Уурхайн зам	-	-	-	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	Үйл ажиллагааны туршид	MNS5917-2008 “Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага”, MNS5916-2008 “Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS5918-2023 “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага”.
	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ургамлан нөмрөг бохирдох	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгартал болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Уурхайн орчим	-	-	-	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	Үйл ажиллагааны туршид	
Амьтны аймаг									
	Хөрсөнд үүрлэдэг жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Уурхайн ойр орчимд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
	амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх								
	Хог хаягдлыг (хоолны) эмх замбраагүй хаяснаас болж зарим махчин амьтад идэх, амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх	Уурхайн хогийн цэг	-	-	-	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан	Үйл ажиллагааны туршид	
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал							3,5		

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2026 онд ил уурхайгаар нийт 0.73 га талбай хамрагдах бөгөөд 20.57 мян.м³ уулын ажил хийгдэж 0,16 га талбай шинээр өртөнө.

Хөрсний гадаргад овоолго болох 2.2 мян.м³ хөрсийг ил уурхайн ил орон зайд тээвэрлэн зөөх ба техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ.

Хүснэгт 10 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлт	Талбайн хэмжээ	Нийт зардал (төг)	
Монгол улсын холбогдох хууль, дүрэм, тогтоол, стандартын дагуу тухайн ордын геологийн тогтоц, бүс нутгийн байгаль цаг уурын онцлогоос хамааруулан зөвхөн уулын ажил болон уурхайн бусад үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээгээд зогсохгүй байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхөн сэргээлтийн ажлуудыг цогц байдлаар хийх юм.	-Хөрсний гадаргад овоолго болох 2.2 мян.м³ хөрсийг ил уурхайн ил орон зайд тээвэрлэн зөөх ба техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. - Шимт хөрсийг уурхайн ашиглалтын үйл ажиллагаа дууссан талбайд зөөвөрлөн тэгшилнэ.	0.16 га	3,845,000	<ul style="list-style-type: none"> - MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.Нэр томьёо, тодорхойлолт.” - MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал - MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах техникийн шаардлага - MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага - MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
Нийт нөхөн сэргээлтийн зардал			3,845,000	

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр: Нөхөн сэргээлтийн ажил нь уурхайн ашиглалтын дараа хийгдэж эхлэх ба жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөөний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрд нь тодруулга хийн шинэчлэн тооцно.

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө

Их булаг барилгын элс-хайрганы орд ашиглах төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах (шилжүүлэх) арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч Зул буян ундрах ХХК нь уурхайн БОМТ-ний хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авсан ажлын хэсгийн зөвлөмж болон орон нутгийн саналыг үндэслэн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн, нөхөн сэргээлтгүй орхигдсон газарт нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах, газрыг цаашид зөвшөөрсөн зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлж, орон нутагт хүлээлгэн өгөхөөр тусгав.

Мөн Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2026 онд Тарагт сумаас санал болгосны дагуу тогтоосон газарт усалгааны системтэй болгох, усны нөөцийн сав тавих. Нэмэгтээр 100 ш улиасны суулгац тарихаар төсөвлөв.

Хүснэгт 11 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилго	Үндэслэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нэг жилийн зардал	Хамтрах талууд
Нөхөн сэргээлтгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийж ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	Газрыг цаашид зөвшөөрсөн зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлж	Ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн, нөхөн сэргээлтгүй орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлт хийх	5,000,000	Өвөрхангай аймаг Тарагт сумын байгаль орчны газар
Тэрбум мод үндэсний хөдөлгөөн Ойн зурвас байгуулах	Экологийн хувьд ижил төстэй газрыг сонгон авч ойжуулах	Тарагт сумаас санал болгосны дагуу тогтоосон газарт усалгааны системтэй болгох, усны нөөцийн сав тавих. 100 ш улиасны суулгац тарих	Үйл ажиллагааны зардал 1,000,000	
			6,000,000	

Соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор **бүртгэгдээгүй**. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн **бүртгэл** мэдээллийн санд заавал **бүртгүүлнэ**.

Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Их булаг-1 барилгын элс-хайрганы орд ашиглах төсөл нь уурхайн гэнэтийн ослын эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг тайлангийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн тул доорх хүснэгтэд хураангуй байдлаар харуулав.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн гэнэтийн ослын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө болон ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2026 онд 3,2 сая төгрөг төсөвлөв.

Хүснэгт 12 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Нефть болон химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжих бүс нутаг	-	Төслийн хугацаанд байнга
Ажлын байрны осол гэмтэл	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Уурхайн ажилчид	0,3	Жил бүр
	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	0,5	2 жилд нэг удаа
Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах		Уурхайн ажилчид	1,5	Жил бүр
Гал унтраах багаж хэрэгсэл байршуулах		Уурхай орчим	1,0	
Нэг жилд			3,2	

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Зул буян ундрах ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах ЗР зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /сая.төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох Шингэн хог хаягдлаар хөрс,газар доорх ус бохирдож болзошгүй	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	0.2	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008
	Ангилан хаях хогийн сав байршуулах	Төслийн эхэнд	ҮАЗардалд	2026 онд	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	0,2	Жил бүр	
	Хаягдал ажилласан тос болон аюултай хог хаягдлыг тусгай саванд цуглуулан зориулалтын цэгт түр хадгалах /түр цэг байгуулах/	Үйл ажиллагааны турш	0,5	Жил бүр	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	0,4	Жил бүр	
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлын хор, аюулын талаарх лавлах мэдээлэл, тэдгээрийг тээвэрлэх болон хадгалах явцад гарч болзошгүй ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сургалт зохион байгуулах		0,1	Жил бүр	
	Хадгалах сав, баглаа боодол стандартын шаардлага хангасан хаяг шошготой байх		0,1		
Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардлын нийт дүн 2026 он			1,5		

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-6200086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Их булаг барилгын элс-хайрганы орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай **бүрд** авч хэрэгжүүлэх шаардлагатай. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх зардлыг үйл ажиллагааны зардалд тусгав.

Хүснэгт 13 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, сая.төг
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
3.	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
5.	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
6.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон Өвөрхангай аймгийн БОАЖГ-т хүргэн өгч байх	Жил бүрийн 11 сард	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
7	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөлгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд	1.0
Нийт зардал			1.0

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч Зул буян ундрах ХХК-д өгөгдсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад Зул буян ундрах ХХК-иас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч ОХШХ-г хэрэгжүүлэхдээ хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэх ба хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын дор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-6200086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 14 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал 2026 онд Сая төгрөг	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Уурхайн талбай дээр ашиглалтын үед	Агаарын найрлага: жилд 2 удаа	1 багаж 40.0 х жилд 2 = 80,0 мян.төг	0.08	<ul style="list-style-type: none"> - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, - MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар		Тоосны хяналт: Олборлолтын талбайд 1 цэгт жилд 2 удаа ,1 удаадаа өдөрт 2 удаа	1 удаагийнх 35.0 х өдөрт 2 удаа х 1 цэг х жилд 2 удаа = 140.0 мян.төг	0.14	
2. Усны хяналт шинжилгээ					
Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn,	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээг хангаж буй гүний худагаас	Жилд 2 удаа Хавар зун	50,0х2х= 100,0 мян.төг	0.1	<ul style="list-style-type: none"> - MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага

**“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-6200086 тоот
Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал 2026 онд Сая төгрөг	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс ус төрөгчид		Ашиглалтын өмнө, явцад, дараа			<ul style="list-style-type: none"> - MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон гээвэрлэх, гарын авлагын зөвлөмж - MNS 13.060.50 Усны чанарын стандарт - MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Усны түвшин (газрын гадаргаас доош, м-ээр)			-		
3. Хөрсний бохирдол					
Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Өнгөн хөрс Уурхай Овоолго	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа намар 1 удаа	3 цэгт х 3 дээж х жилд 2 удаа х /45.0/= 140,0 мян.төг /Хөрсний химийн шинжилгээ -25.0 төг, хүнд металлын шинжилгээ 1 дээж- 45.0 төг/	0.27	<ul style="list-style-type: none"> - MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
ОХШХ-ийн 2026 оны зардал				0.59	

“Зул буян ундрах” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт хэрэгжих MV-62000086 тоот Их булаг-1 Барилгын элс-хайрганы ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө , орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч Зул буян ундрах ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаарх тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй аймгийн байгаль орчны газар, сумын засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 15 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль Орчин Аялал Жуулчлалын яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	Жилийн эцэст (12.01-нд)	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс	Улаанбаатар хот
Өвөрхангай аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	Жилийн эцэст (11.01-нд)	Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах	Өвөрхангай аймаг